




ДУАГ

ДУНГОВЬ АЯМГИЙН АУДИТЫН ГАЗАР

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



Сангийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн, авлагыг
баталгаажуулаагүй байна.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Дундговь аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Т.ОЮУНЧИМЭГ Аудитын менежер Х.НАРАНЦАЦРАЛ Ахлах аудитор Б.ГАНТУЯА, Аудитор Т.ОЮУН-ЭРДЭНЭ Шинжээч Ж.УГТАХБАЯР С.ЖАЛБАА 2016 оны 9 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593113 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг Нутгийн удирдлагын ордон	Товчилсон үгс Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг1. Сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан боловч мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаагүй байна . 1.1. Сангийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн боловч мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу гүйцэтгэж бүртгэсэн байна. 1.2. Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Бүлэг 2. Бараа материалын зарцуулалтыг холбогдох заавар журмын дагуу тайлагнаагүй мөн хугацаа хэтэрсэн авлага өссөн байна. 2.1 Бараа материалын зарцуулалтыг холбогдох заавар журамд нийцүүлэн тайлагнаагүй. 2.2 Өр, авлагыг хууль журмын дагуу бүртгэж тайлагнасан ч хугацаа хэтэрсэн авлага өссөн. Дүгнэлт Зөвлөмж
---	--

Товчилсон үгс

АОУС	Аудитын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ХЭСЗ	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл
АОД	Ажил олгогчийг дэмжих
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХЭНХ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл хоршоо
ХЭДТХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
НББ	Нягтлан бодох бүртгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Үндэсний Аудитын газрын харьяа Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д тодорхойлсон төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014, 2015, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулж ил тод тайлагнасан эсэх,
- Хөрөнгийн зарцуулалт, өр авлагыг үнэн зөв тооцож тайлагнасан эсэх,

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Аудитын олон улсын стандарт,
- Төрийн хяналт шалгалтын стандарт,
- Төрийн аудитын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Төрийн сангийн төлбөр тооцооны журам,
- Бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АОУС, АДБОУС, Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судалгаа хийх;
- ХЭДС-ийн удирдлага, санхүүгийн ажилтнуудаар холбогдох мэдээ, судалгаа гаргуулах;
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, давтан тооцоолол, түүврийн сорил хийх;
- Объект дээр тулган баталгаажуулалт, хяналт хийх зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэлээ.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Хамарсан хүрээ

Эрсдэлийн аудитад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлан, төсвийн төсөөлөл, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, зээл олгосон төсөл хөтөлбөрүүд, Хөдөлмөрийн хэлтсийн төсвийн шууд захирагчийн гаргасан тушаал, шийдвэрүүд, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, холбогдох бусад эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Аудит хийх хугацаа, багийн бүрэлдэхүүн

Аудитыг 2016 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 10 дугаар сарын 04-нийг хүртэл хугацаанд, тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал аудитын үе шатны ажилд чанарын хяналт хийж, ахлах аудитор Б.Гантуяа, аудитор Т.Оюун-Эрдэнэ, шинжээч С.Жалбаа, Ж.Угтахбаяр нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Аудитаар нийт 363.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 332.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 31.1 сая төгрөгийн зөрчилд засаж сайжруулах 5 заалт бүхий зөвлөмж өглөө.

Сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулж, ил тодоор тайлагнасан уу?

Бүлэг 1

Сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан боловч мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаагүй байна .

Ерөнхий мэдээлэл

Төрөөс хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараах бодлогыг баримталж байна. Үүнд:

- Хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой түвшинг хангах;
- Ажиллах хүчнийг хөрөнгө оруулалт, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн иргэний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл судалгааг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанар үр ашгийг дээшлүүлэх;
- Ажиллах хүчний дотоод зах зээлийг эзэмших, гадаадын зах зээлд мэргэшил, чадвар дээшлүүлэх.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч хамрагддаг.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү, гадаад иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр, гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл, гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс ХЭДС-д оруулсан хандив тусламж, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

ХЭДС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулна. Үүнд:

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- Ажилд зуучлах, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
- Ажил олгогчийг дэмжих, нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
- Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаа

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэж хэвлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэх;
- Сумын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар сум хөгжүүлэх санд хөрөнгө хуваарилах зэрэгт зарцуулна.

1.1 Сангийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн боловч мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу гүйцэтгэж бүртгэсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан нь улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө, сангийн хөрөнгийг банканд хадгалуулсны хүү, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрөөс бүрдэнэ.

ХЭДС нь 2015 онд улсын төсвөөс 764.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 735.0 сая төгрөгийн санхүүжилт авч хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрөөс хуулийн дагуу ААНБ-аас төлөх төлбөрөөс 5.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөө баталсныг огт төвлөрүүлээгүй, зээлийн эргэн төлөлтөөс 287.0 сая төгрөг орж нийт 1,022.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэртэй үйл ажиллагаагаа явуулжээ. Тухайн онд 724.4 сая төгрөгийг зарцуулж, 297.5 сая төгрөгийг Хөдөлмөрийн яаманд төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайлангаар орлогыг 1,022.3 сая төгрөг буюу 0.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь буцаж орсон гүйлгээтэй холбоотой байна.

Харин 2016 онд улсын төсвөөс 756.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас хагас жилийн байдлаар 643.0 сая төгрөгийн санхүүжилт авч, хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрөөс 10.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс орлого огт төвлөрүүлээгүй, зээлийн эргэн төлөлтөөс 68.4 сая төгрөгийг оруулж, эхний үлдэгдэл 0.3 сая төгрөг, нийт 711.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэртэй ажилласан байна. Тайлант оны 2 дугаар улиралд 323.6 сая төгрөгийг зарцуулан 64.9 сая төгрөгийг Хөдөлмөрийн яаманд төвлөрүүлэн 323.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. /Хүснэгт №1.1/

Үзүүлэлт	2015			2016		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Батлагдсан төсөв	764.9	735.0	(29.9)	756.0	643.0	(113.0)
Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөр	5.0	-	(5.0)	10.0		(10.0)
Авлагын бууралт		287.0	287.0		68.4	68.4
Орлогын дүн	769.9	1,022.0	252.1	766.0	711.4	(54.6)
Зарцуулалт	735.0	724.4	(10.6)			-
Төвлөрүүлэг		297.5	297.5			-
Үлдэгдэл	34.9	0.0	(34.9)	766.0	711.4	(54.6)

ХЭДТХ-нд орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилахаар заасан боловч орон нутгаас төсөв батлаагүй, Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг төвлөрүүлээгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаа

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 2¹-т заасны дагуу 2015 онд 5.0 сая төгрөгийн, 2016 онд 10.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдан гүйцэтгэл 0 хувьтай байна. 2014, 2015 онуудад төсвийн байгууллагуудад ХБИ-г ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүйн төлбөрийг авах тухай албан бичгийг хүргүүлсэн боловч үр дүнд хүрээгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөрийг Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолын дагуу тооцоолж үзэхэд жилд ААНБ-аас 15.2 сая төгрөгийн, төсвийн байгууллагаас 15.9 сая төгрөгийн, нийт 31.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломжийг алдсан байна. /Хавсралт № 1/

Сангийн зарцуулалтыг 2015 он, 2016 оны эхний хагас жилийн байдлаар хөтөлбөр тус бүрээр харууллаа. /Хүснэгт 1.2/

Хүснэгт 1.2
/мөнгөн дүн сая төгрөгөөр/

№	Хөтөлбөр	2015.12		2016.06	
		мөнгөн дүн	эзлэх хувь	мөнгөн дүн	эзлэх хувь
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ	8.0	1.1	14.5	4.5
2	Ажилд зуучлах үйлчилгээ	2.4	0.3	0.2	0.1
3	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	171.9	23.7	128.2	39.6
4	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	72.6	10.0	34.0	10.5
5	Залуучууд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	81.2	11.2	32.3	10.0
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	48.0	6.6	44.6	13.8
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	201.1	27.8		
8	Бусад хөтөлбөр	139.3	19.2	69.9	21.6
	Нийт	724.4	100.0	323.6	100.0

Судалгаанаас харахад 2015 онд сангийн нийт зарцуулалтын 27.8 хувийг малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр эзэлж байсан бол 2016 оны эхний хагас жилийн байдлаар 39.6 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр эзэлж байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих

Тус хөтөлбөрт жижиг зээл олгох, санхүүгийн дэмжлэг олгох, аж ахуй эрхлэлтийн сургалт явуулах, борлуулалтын болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх, бүлгийн зохион

¹ Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаа байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ зэрэг арга хэмжээнүүд хамаарна.

2015 онд 86 ажлын байр бий болгох 67 төслийг сонгон шалгаруулж 120.0 сая төгрөгийг, 2016 онд 90 ажлын байр бий болгох 90 төслийг сонгон шалгаруулж 89.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус олгосон байна.

ХЭСЗ-ийн хурлаар төслийг сонгон шалгаруулдаг боловч зарим санхүүгийн дэмжлэгийг оновчтой хуваарилаагүй байна. Тухайлбал:

- Аудитын явцад төсөл хэрэгжүүлэгч 12 иргэнтэй уулзаж төслийн хэрэгжилтийг үзэхэд 5 төсөл нь хангалтгүй, үйл ажиллагаа явуулаагүй;
- Зорилтот бүлэгт олгох ёстой санхүүгийн дэмжлэгээс 1.0 сая төгрөгийг үйл ажиллагаа нь тогтворжсон “Өег бууз” цайны газарт олгосон;
- Улаанбаатар хотын харьяалалтай 2 иргэн /Ц.Ганбаатар, Н.Бат-Эрдэнэ/-д 1.4 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Малчин, ХХЭНХ байгуулах иргэнийг дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг тус сангаас олгох бөгөөд сангаас олгох жижиг зээлийг банкаар дамжуулан олгохоор заасан байна.

Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн хэлтэс, орон нутгийн арилжааны банкуудтай хамтарч ажиллах 3 талт гэрээг 2013 оны 9 сард байгуулсан байна. Жижиг зээл олгох зориулалтаар Төрийн банканд 71.8 сая төгрөг, Хаан банканд 178.2 сая төгрөг, Хас банканд 50.0 сая төгрөгийг тус тус олгожээ.

2016 оны 2 дугаар улирлын байдлаар Хаан банкнаас 21.8 сая төгрөг, Хас банкнаас 14.7 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Арилжааны банкнуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг шалгахад дараах зөрчилтэй асуудлууд байна. Үүнд:

- Арилжааны банкуудтай 2013 оны 9 дүгээр сараас 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 3 сарын хугацаатай байгуулсан гэрээний зарим заалтууд зөрчилтэй байна. Тухайлбал гэрээний 4.14-д *“Энэ гэрээний 1.2-д заасан зээлийн эх үүсвэрийг гэрээ байгуулагдсан хугацаанаас хойш 6 сарын дотор зээл олголтод бүрэн гаргана, 1.4-д зээлийн хугацаа 24 сар хүртэл...”* зааснаар эх үүсвэрийг ХЭДС-д буцаан төвлөрүүлэх хугацааг тооцох боломжгүй байна.
- Гэрээний 7.1.6-д зааснаар гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа дууссан тохиолдолд банк нь зээлийн эх үүсвэрийг үл маргах журмаар ХЭДС-д эргүүлэн төвлөрүүлэх ёстой ч гэрээний эрх үүргийн биелэлтийг тооцож дүгнээгүй, гэрээ сунгасан эсвэл цуцалсан тухай гэрээлэгч талуудын хүсэлт, шийдвэр гараагүй байхад 2014 оны 11 сард дахин хамтарч ажиллах гэрээг Хөдөлмөрийн хэлтэс Хас банктай байгуулжээ.
- 7.4-д *“Банк нь зээлийн эх үүсвэрийг ХЭДС-д гэрээний хугацаанд эргүүлэн төлөөгүй бол зээлийн эх үүсвэрийн дүнгээс хугацаа хоцорсон хоног тутамд 0.1 хувийн алданги тооцож, ХЭДС-д төлнө”* заасан боловч алданги тооцоогүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр

Аудитын хамрах хугацаанд /2015он, 2016 оны 2 дугаар улирал/ ажил идэвхитэй хайж байсан 30 иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар тасралтгүй төлсөн 22 ААНБ-д нийт 66.4 сая төгрөгийн АОД урамшууллыг олгосон байна.

Аудитын явцад дээрх 30 иргэнээс 15 иргэнийг сонгож, “хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сан”-ийн бүртгэл, ажил эрхлэлтийн байдлыг шалгахад программд бүгд бүртгэлтэй боловч 7 иргэн буюу түүвэрт хамрагдсан /15/ иргэдийн 46.7 хувь нь ажлаасаа гарсан байлаа. Ажил олгогчоос ажлаас гарсан шалтгааныг тодруулахад ажилтан өөрийн хүсэлтээр гарсан гэсэн тайлбарыг өгсөн.

Хөдөлмөрийн хэлтэс, урамшуулал авсан ААНБ-ын хооронд байгуулсан АОД арга хэмжээний гэрээнд болон ХЭҮЗ-ийн 2015 оны 7 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад ажилтныг цаашид тогтвор суурьшилтай ажиллуулах талаар заагаагүйгээс ААНБ-ууд иргэнийг ажилд аваад цалин хөлсийг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоож 12 сар ажиллуулаад урамшуулал авсаны дараа ажлаас чөлөөлөх хандлага ажиглагдаж байна. Энэ нь ажил хайгч иргэний хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдал алдагдах, хөтөлбөрийн үр дүнг бууруулах, ажил олгогчид зөвхөн ХЭДС-с урамшуулал авах зорилгоор хөтөлбөрт хамрагдах сөрөг үр дагавар бий болгох эрсдэлтэй. Иймд гэрээнд тогтвортой ажиллуулах талаар тодорхой заалт оруулах шаардлагатай байна.

ХЭҮЗ-ийн 2015 оны 7 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 5.6²-т заасныг зөрчиж, зарим урамшууллыг олгохдоо бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд өрхийн үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, эдийн засгийн албан бус салбарт ажиллагч, ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг хамруулна гэж заасны дагуу иргэдийг сургалтанд хамруулж, 2015 онд 15.6 сая төгрөгийн, 2016 онд 24.6 сая төгрөгийн сургалтын зардлыг тус тус зарцуулсан байна.

Залуучууд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

2015 онд 1 бүлэгт 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг, 5 бүлэгт 50.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож гэрээ байгуулан ажиллажээ. Мөн 8 төгсөгчийг нийтийг хамарсан ажилд зуучлан нийт 1.9 сая төгрөгийн цалингийн дэмжлэг үзүүлэн түр ажлын байраар хангасан байна.

Харин 2016 оны 6 сарын байдлаар МСҮТ-ийн төгсөгчдөөс нийт 47 төслийг хүлээн авч 7 төслийг сонгон шалгаруулж 34.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Аудитын явцад төсөл нь шалгарсан барилгын халаалт, цэвэр, бохир ус шугам засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бүлэгтэй уулзаж төслийн хэрэгжилт, үйл ажиллагаатай нь танилцлаа.

² Энэхүү журмын 5.3, 5.4-д заасан урамшуулал, цалингийн дэмжлэг олгох арга хэмжээнд хамрагдах ажил олгогч ажилд орж байгаа иргэнд цалингийн картаар цалин хөлсийг олгож, баримт бүрдүүлнэ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын
санхүүгийн үйл ажиллагаа

Төсөлд худалдан авахаар тооцсон тоног төхөөрөмжийн жагсаалтыг худалдан авч ашиглаж байгаа тоног төхөөрөмжтэй тулган үзэхэд тохирч байсан ба бүлгийнхэн засварын ажлын захиалгатай, тоног төхөөрөмжүүдээ ашиглаж байв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд шалгарсан төсөлд 2015 онд 43 иргэнд 45.0 сая төгрөгийн, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 59 иргэнд 55.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлсэн байна. Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтнээс авсан судалгаа, банканд шилжүүлсэн гүйлгээний жагсаалт, ХБИ-ээс авсан судлагаануудыг тулган шалгахад тохирч байлаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Малжуулах төсөлд 2015 онд 13 сумын 45 малчин өрхийг хамруулж 192.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Малыг тухайн сумын үнэ ханшаар худалдан авдаг ба сум бүр харилцан адилгүй үнэ ханштай байна.

Тус хөтөлбөрт нийт 201.1 сая төгрөгийг зарцуулснаас бусад зардалд 4.5 хувь буюу 9.1 сая төгрөгийг зарцуулсан нь журмын заалтыг хангаж ажиллажээ.

2016 оны 2 дугаар улирлын байдлаар малчдын ирүүлсэн төсөл хөтөлбөрт хяналт хийж, шалгаруулалтын шатны ажил хийгдсэн байна.

1.2 Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2014 оны 07 дугаар сарын 01-ны өдөр батлагдсан Шилэн дансны тухай хуулиар байгууллага бүр өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон санхүүгийн үйл ажиллагааг цахим хуудсаар нийтэд ил тод мэдээлэхээр хуульчилсан.

Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1³-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг эрсдэлийн аудитын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2015 онд шилэн дансны цахим хуудсанд жилийн эцсийн тайлан, аудитын дүгнэлтийг мэдээлсэн боловч хэлтсийн даргын тушаал, шийдвэрүүд болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй гүйлгээ, сар улирлын мэдээг огт мэдээлээгүй байна. Энэ нь хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 *“мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”* гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.
- Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д */Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлнэ/* заасныг тус тус зөрчсөн байна.

³ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ

Цаашид шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, мэдээлэл үнэн зөв, бодитой
иж бүрэн байх гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Хөрөнгийн зарцуулалт, өр, авлагыг үнэн зөв тооцож тайлагнасан уу?

Бүлэг 2

Бараа материалын зарцуулалтыг холбогдох стандартад нийцүүлэн тайлагнаагүй мөн хугацаа хэтэрсэн авлага өссөн байна.

2.1 Бараа материалын зарцуулалтыг холбогдох заавар журамд нийцүүлэн тайлагнаагүй.

ХЭДС-аас хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой бичиг хэрэг, шатахуун, сургалтын цай, хоолны зардлууд гардаг байна.

Аудитаар бараа материалын дансанд анхан шатны баримтын бүрдэлд түүврийн сорил хийх, зарцуулалтыг давтан тооцоолох, судалгаа шинжилгээ хийх, үлдэгдэлд хяналтын тооллого хийх зэрэг горим сорилуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Гэвч худалдан авсан бараа материалыг хөрөнгийн дансанд орлого аваагүй нь горим сорил, давтан тооцоолол хийх боломжгүйд хүргэлээ.

Бараа материалын зарцуулалтыг анхан шатны баримтаас хөөн шалгахад хөтөлвөл зохих анхан шатны маягтыг бүрэн хөтлөөгүйгээс /шаардах хуудас/ хөтөлбөр тус бүрд хэдий хэмжээний материал зарцуулсан гэдгийг тооцох боломжгүй байна. Энэ нь төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтний ажлын хариуцлага сулрах, сангийн хөрөнгө хяналтгүй зарцуулагдах, улмаар залилан үүсч болзошгүй эрсдэлтэйг анхаарах нь зүйтэй.

Хөдөлмөрийн яамнаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.13.1-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл тайлагналын онцлогыг тодорхойлсон байна. Тус баримт бичгийн 4.13.1.1-д төсөл хөтөлбөр болон бусад үйл ажиллагаатай холбогдон гарсан 1 удаагийн шинж чанартай материалын зардлыг /бичиг хэргийн, шатахууны болон цай хоолны/ тухайн арга хэмжээний төсөв, анхан шатны баримтыг үндэслэн / шаардах хуудас/ гүйцэтгэл нь бүрэн гарсан бол шууд зардалд бичиж болно гэж заажээ.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2⁴ дахь заалттай нийцэхгүй байна.

Сургалттай холбогдон гарсан бичиг хэргийн, шатахууны, цай хоолны зарцуулалтыг тайлагнахдаа НББ-ийн анхан шатны маягтыг бүрэн хөтлөхгүй байгаа нь:

- Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 06 дугаар сарын 18 өдрийн 171/111 тоот тушаалын хавсралт 3.1 өмчийн бүх хэлбэрийн Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар 1-д *"Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл*

⁴ аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаа *ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ*” заасныг;

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг, зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно*” мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “*Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно*” заасан заалтуудыг тус тус зөрчиж байна.

Харин 2016 оноос эхлэн хангамжийн материал болон шатахууныг хөрөнгийн дансанд орлого авч, журналын бичилт хийж, сургалтанд хамрагдсан хүмүүсийн мэдээллийг бүртгэсэн байна. Гэвч бараа материалын зарцуулалтын гүйцэтгэлийг тайлагнахдаа НББ-ийн анхан шатны батлагдсан маягтуудыг хөтлөөгүй, төлөвлөсөн зардлын төсөвтэй харьцуулж хяналгүйгээр сургалтын батлагдсан удирдамжийг үндэслэн шууд зардалд тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5⁵-д заасан заалтыг зөрчиж байна.

Гэрээгээр ажил үүрэг гүйцэтгүүлэхдээ автомашин түрээслэх гэрээ байгуулж байгаа нь тохиромжгүйгээс гадна нийт 8.6 сая төгрөгийн шатахууныг зарцуулан хөрөнгийн дансанд орлого авалгүйгээр зардалд шууд тайлагнасан байна. Гэрээнд хэдэн километр явах, хэдэн литр бензин зарцуулах зэргийг тодорхой заагаагүй, мөн ажил хариуцсан мэргэжилтэн болон гэрээ байгуулсан жолооч нь гүйцэтгэлийн тайлан бичээгүй, шатахууны зарцуулалтанд хэрхэн хяналт тавьдаг нь тодорхойгүй байна.

2016 оны хагас жилийн байдлаар 1.6 сая төгрөгийн шатахууныг хөрөнгийн дансанд орлого авсан боловч шатахуун зарцуулалтыг жишиг нормоор бодож тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. Энэ алдаа зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д “*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*” заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар баталсан жишиг нормыг мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актаар баталгаажуулж байх талаар хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Цаашид харьяа яамны НББ-ийн бодлогын баримт бичиг болон холбогдох стандартад нийцүүлэн дэд сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж мөрдөх, бараа материалын зарцуулалтанд хяналт тавих, бүртгэл тайлагналыг УСНББОУС, НББОУС-д нийцүүлэн хөтлөх нь зүйтэй.

⁵ Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна

2.2 Өр, авлагыг хууль журмын дагуу бүртгэж тайлагнасан ч хугацаа хэтэрсэн авлага өссөн байна.

ХЭДС-ийн 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд авлагын эхний үлдэгдэл 273.6 сая төгрөг, тайлант хугацааны эцэст 205.2 сая төгрөгөөр тайлагнасан нь 68.4 сая төгрөгөөр буюу 25.0 хувиар буурсан байна. Тус авлага нь Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн авлага, хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн авлагаас бүрдсэн бөгөөд тайлант хугацаагаар үлдэгдлийг харуулбал: /Хүснэгт № 2.1/

/сая төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	2014 оны үлдэгдэл	2015 оны үлдэгдэл	2016 оны эхний хагас жил
Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэдийг дэмжих хөтөлбөрийн авлага	303.1	91.8	76.4
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн авлага	101.4	181.7	128.7
НИЙТ ДҮН	404.5	273.5	205.1

➤ Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэдийг дэмжих хөтөлбөрийн авлага:

Тус хөтөлбөр нь хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэний аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулах, жижиг зээл олгон санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг байна.

Энэ хөтөлбөрт хамрагдсан иргэдэд олгож байгаа дэмжлэгийг ХААН банк, ХАС банк, Төрийн банк болон ХЭДС-аар дамжуулан олгосон байна. Тус авлагын үлдэгдэл болон өөрчлөлтийг графикаар харуулбал: График 2.1 /сая төгрөгөөр/




Графикаас харахад 2013 онд Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл хоршоо байгуулах иргэнд жижиг зээл олгох үйл ажиллагааг банкаар дамжуулан гүйцэтгүүлэхээр Хас банканд 50.0 сая, ХААН банканд 178.2 сая, Төрийн банканд 71.8 сая төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг олгож, авлагаар тайлагнасан байна. Гэрээний хүчинтэй хугацаанд Төрийн банк эх

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаа үүсвэрийг бүрэн, ХААН банк 160.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж 17.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, ХАС банк 35.3 сая төгрөгийг төвлөрүүлж 14.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Харин 2015 онд ХЭДС-аас 120.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг иргэдэд олгон журмын дагуу 50 хувь буюу 60.0 сая төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна. Уг зээлийн гэрээнд санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд эргэн төлөлт хийх гэрээ байгуулан ажилласан ч гэрээний 4.4 /Хавсралтанд тусгагдсан “Эргэн төлөлт хийх төлөвлөгөө”-ний дагуу эргэн төлөлт хийнэ/-д зааснаар төлөгч тал хүлээх үүргээ хэрэгжүүлээгүй, төсөл хэрэгжүүлэгч тал нь 2.6⁶-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүйгээс авлагын эргэн төлөлт удааширч, хугацаа хэтэрсэн авлага үүсэхэд нөлөөлсөн байна. Үүнийг графикаар харуулбал:

график 2.2



Графикаас харахад 2015 онд 8.0 сая төгрөг эргэн төлөгдөхөөс 6.9 сая төгрөг нь төлөгдөж 1.1 сая төгрөг буюу 13.7 хувь нь хугацаа хэтэрсэн, 2016 оны эхний хагас жилийн эргэн төлөлт 36.4 хувь болж өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа нь гэрээний үүргийн хэрэгжилт буурсан байна. Тус хөтөлбөрийн авлага нь 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан дахь нийт авлагын 37.3 хувийг эзэлж байна.

Мөн ХХЭНХ-ийн авлагад 2003, 2004 онуудад үүссэн насжилт өндөр 7 иргэний 3.2 сая төгрөгийн авлага байснаас 2015 онд 0.7 сая төгрөг нь төлөгдсөн байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн авлага:

Хөтөлбөрийн зорилго нь малчны мал маллах, аж ахуй эрхлэх ур чадвар олгох, малжуулах, хадлан тэжээл бэлтгэх, сүү цагаан идээ болон мал аж ахуйн багаж тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгддэг.

Хөдөлмөрийн хэлтэс 2014-2016 онуудад дээрх арга хэмжээнүүдээс малчин өрхийг малжуулах арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийг ХЭДС-ийн төрийн сан дахь харилцах дансаар дамжуулан олгосон байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан малчдаас авах авлага нь 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан дахь нийт авлагын 62.7 хувийг эзэлж байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан малчдаас авах авлагын үлдэгдэл 2014 оны эхэнд 101.4 сая төгрөг байсан бол 2015 оны эхэнд 181.7 сая төгрөг болж 80.3 сая төгрөг буюу 79.2 хувиар өссөн. Харин 2016 оны эхний хагас жилийн байдлаар 53.0 сая төгрөг буюу 29.2 хувиар буурч, 128.7 сая төгрөг болсон байна. Энэ нь:

- 2015 онд малжуулах төсөлд 45 малчныг хамруулан нийт 192.0 сая төгрөгийг олгож Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2.2.4 /Санхүүгийн дэмжлэгийн 50 хувийг мал худалдан авч өгснөөс хойш 24 сарын дотор эргүүлэн төлөх бөгөөд .../-д


⁶ Хавсралтанд тусгагдсан В талын боловсруулсан “Эргэн төлөлт хийх төлөвлөгөө”-ний биелэлтэнд хяналт тавьж, төлөвлөгөөний дагуу эргэн төлөлтийг хийхийг шаардах эрхтэй

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаа заасны дагуу 50 хувь буюу 96.0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр авлагаар тайлагнасан

- Гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2015 онд нийт 20.0 сая төгрөг төлөгдөхөөс 15.7 сая төгрөг буюу 78.5 хувь нь төлөгдсөн
- Мөн хуваарийн дагуу 2016 онд 88.0 сая төгрөг төлөгдөхөөс 52.9 сая буюу 60.2 хувь төлөгдсөн зэрэгтэй холбоотой байна.

Тус авлагын үлдэгдэл, өсөлт бууралтыг графикаар харуулбал:

График 2.3




Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 39.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага үүссэн нь нэг талаас хөтөлбөрт хамрагдсан малчид гэрээний үүргээ биелүүлээгүйтэй холбоотой бөгөөд нөгөө талаас хариуцсан мэргэжилтэн хяналт тавих

үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллагаагүйгээс шалтгаалсан байна. Энэ нь гэрээний эрх үүрэг зөрчигдөх, малчид болон холбогдох албан тушаалтны ажлын хариуцлага сулрах эрсдэлтэйг анхаарч ажиллах нь зүйтэй. Үүнийг графикаар харуулбал:

График 2.4

/сая төгрөгөөр/



Графикаас харахад хугацаа хэтэрсэн авлагын эргэн төлөлтийн хувь өмнөх оноос 21.5-с 39.8 болж өссөн, 2016 онд малжуулах арга хэмжээнд нэмж зээл олгоогүй байхад авлагын үлдэгдэл бодитой буураагүй нь хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар хангалтгүй ажиллажээ гэж дүгнэхээр байна.

Аудитын явцад малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан санхүүжилт, харилцах дансны орлогын гүйлгээнд түүврийн сорил хийж, малчдын хөтөлбөрт хамрагдсан шалгуур, баримт бүрдүүлэлтийг тулган баталгаажуулж, зээлийн эргэн төлөлтөд авлагын давтан тооцоолол хийлээ.

Түүврийн сорил, авлагын давтан тооцооллоор алдаа зөрчил илрээгүй, санхүүгийн тайлантай тохирч байна.

Харин авлагыг төсөлд хамрагдсан малчин тус бүрээр давтан тооцоолох явцад Сайхан-Овоо сумын мэргэжилтэн Р.Тунгалагтуяа, Эрдэнэдалай сумын мэргэжилтэн Ш.Дашдорж нарын нэр дээр нийт 1.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэл бүртгэлтэй байгаа нь хэзээ үүссэн,

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаа хөтөлбөрт хамрагдсан малчидтай хамаатай эсэх нь тодорхойгүй байна. Энэ авлагын үлдэгдлийн шалтгааныг тогтоох, аудитын явцад барагдуулах, цаашид анхаарч ажиллах талаар аудитын явцад зөвлөмж өгч ажиллаа.

Мөн малчдын хөтөлбөрт хамрагдсан төслүүдийн шалгуур хангасан байдал, баримт бүрдүүлэлтийг тулган баталгаажуулах явцад багийн даргын тодорхойлолт зөрүүтэй байна. Мөн малыг хонин толгойд шилжүүлэхдээ зөрүүтэй тооцсон. Тухайлбал: 2 малчны малыг 6-аар дутуу, 17 малчны малыг 35 хүртэл илүү толгойгоор тооцсон байсныг аудитын явцад зөвлөмж өглөө.

ХЭДС-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлагын данстай холбоотой дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 237.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д *“Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах”* заасныг зөрчсөн
- 2016 оны эхний хагас жилийн байдлаар 50.0 сая төгрөгийн авлага эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлөгдөөгүй гэрээний хугацаа хэтэрсэн нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэдийг дэмжих, малчин өрхийг малжуулах гэрээний 2.6 */Хавсралтанд тусгагдсан В талын боловсруулсан “Эргэн төлөлт хийх төлөвлөгөө”-ний биелэлтэнд хяналт тавьж, төлөвлөгөөний дагуу эргэн төлөлт хийхийг шаардах эрхтэй/* -д заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй
- Хамтран ажиллахаар 2013 оны 09 дүгээр сард байгуулсан гэрээний дагуу олгосон зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл болох Хас банкны 14.6 сая төгрөг, ХААН банкны 17.3 сая төгрөгийг ХЭДС-д тус тус буцаан төвлөрүүлээгүй байна.

Дээрх зөрчлүүдийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар хугацаатай албан шаардлага хүргүүллээ. Аудитын явцад нийт 13.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулсан.

ДҮГНЭЛТ

Аудитаар цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг өгч байна.

1. Сангийн эх үүсвэрийг дутуу бүрдүүлсэн байна.
2. Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
3. Хангамжийн болон бараа материалын зарцуулалтын анхан шатны баримтыг хөтлөөгүй байна.
4. Хөдөлмөрийн яамнаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.
5. Арилжааны банкнууд эх үүсвэрийг ХЭДС-д хугацаанд нь бүрэн төвлөрүүлээгүй, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөх хугацаа хэтэрсэн авлага өссөн, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга, нягтлан бодогч нарт зөвлөж байна. Үүнд:

- Сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд санаачлагатай ажиллах
- Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- Хангамжийн болон бараа материалын анхан шатны баримтыг бүрэн хөтлөх, зарцуулалтанд хяналт тавих
- Дэд сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж мөрдөх
- Арилжааны банкнудаас авах авлагын үлдэгдлийг ХЭДС-д бүрэн төвлөрүүлэх, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөх хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж хэвших

ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Хавсралт №1

25 ба түүнээс дээш ажилчидтай ААН байгууллагад ноогдох ХБИ, төлбөр

№	Ажил олгогчийн нэр	Ажилчдын тоо	Ажиллах ХБИ-ний норм	Ажиллаж байгаа ХБИ	Зөрүү	ХБИАТ	
						Төсвийн	ААН
1	Говийн Ирээдүй Цогцолбор сургууль	98	3	2	1	691.2	0
2	12 жилийн 3-р сургууль	53	2	2	0	0	0
3	МГССургууль	55	2	2	0	0	0
4	Эрдмийн Далай Цогцолбор сургууль	116	4	3	1	691.2	0
5	5-р цэцэрлэг	28	1	0	1	691.2	0
6	Аймгийн ЗДТГ	58	2	1	1	691.2	0
7	Мэргэжлийн хяналтын газар	36	1	1	0	0	0
8	МСҮТ	70	2	0	2	1382.4	0
9	ЦУШОШ алба	58	2	0	2	1382.4	0
10	Татварын хэлтэс	33	1	1	0	0	0
11	Төв халхын дуулалт жүжгийн театр	61	2	1	1	691.2	0
12	Нэгдсэн эмнэлэг	195	7	6	1	691.2	0
13	Сайнцагаан сумын ЗДТ	36	1	1	0	0	0
14	Ган Илч ХХК	80	3	0	3	0	2073.6
15	Дундговь Ус ОНӨҮГ						
16	Мандалговь хүнс ХХК	38	1	0	1	0	691.2
17	ХААН банк	90	3	0	3	0	2073.6
18	ЦШС салбар	79	3	0	3	0	2073.6
19	2-р цэцэрлэг	26	1	0	1	691.2	0
20	4-р цэцэрлэг	26	1	0	1	691.2	0
21	6-р цэцэрлэг	26	1	0	1	691.2	0
22	НДХэлтэс	58	2	0	2	1382.4	0
23	НХҮХэлтэс	39	1	0	1	691.2	0
24	Улсын бүртгэл	30	1	0	1	691.2	0
25	БМБХ ХХК	33	1	0	1	0	691.2
26	МХС ТӨК	49	1	0	1	0	691.2
27	НИК ХХК	33	1		1	0	691.2
28	Номгон рашаан ХХК	26	1		1	0	691.2
29	Холбоо	25	1		1	0	691.2
30	Цахилгаан түгээх сүлжээ	79	3		3	0	2073.6
31	Төрийн банк	72	2		2	0	1382.4
32	Шуудан үйлчилгээний газар	23	1	1	0	0	0
33	Дэлгэрцогт Сургууль	37	1	1	0	0	0
34	Дэрэн Сургууль	47	1	1	0	0	0

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын
санхүүгийн үйл ажиллагаа

35	Хулд Сургууль	45	1		1	691.2	0
36	Өлзийт Сургууль	42	1	1	0	0	0
37	Гурвансайхан Сургууль	39	1	1	0	0	0
38	Цагаандэлгэр Сургууль	26	1	1	0	0	0
39	Говь-Угтаал Сургууль	38	1	1	0	0	0
40	Говь-Угтаал Эмнэлэг	31	1	1	0	0	0
41	Луус Сургууль	43	1	1	0	0	0
42	Сайхан-Овоо Сургууль	42	1	1	0	0	0
43	Адаацаг Сургууль	42	1		1	691.2	0
44	Дэлгэрхангай Сургууль	58	2	3	-1	0	0
45	Эрдэнэдалай Сургууль	101	4		4	2764.8	0
46	Эрдэнэдалай Эмнэлэг	44	1	1	0	0	0
47	Өндөршил Сургууль	40	1	1	0	0	0
48	Баянжаргал Сургууль	29	1	1	0	0	0
Нийт дүн			80	36	44	15897.6	15206.4

Холбогдох байгууллагын санал

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1-ийн дагуу аудитын тайлангийн төслийг
аудит хийлгэсэн байгууллагад хүргүүлж санал тайлбарыг авлаа.

*Тамгасан
Тайланг хүргүүлж
2016.10.12*



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг
Утас: 7059-2109, 7059-2480, 7059-2262

Факс: 7059-3986

E-mail: www.dundgobi.hh.gov.mn

2016.10.12 № 11
танай -ны № -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Үндэсний аудитын газрын харъяа Дундговь
аймгийн аудитын газраас ирүүлсэн 263 тоот албан
бичиг, тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангын төслийн 1.1-д тайлбар хүргүүлж
байна. 2014 онд ААН, байгууллагуудад 111 дүгээр зүйл
заалтыг хэрэгжүүлэхээр Хэлтсийн даргын албан тоотыг
хүргүүлж мөн үүнийхээ хэрэгжилтийг хангуулах талаар
ажил хариуцсан мэргэжилтнүүд тухайн байгууллагуудад
удаа дараа очиж шаардлага тавьж ажилласан.

2014 оны үйл ажиллагаанд дүгнэлт хийж 2015
онд аймгийн МХГазартай хамтран тус ажлыг
сайжруулах ажлын хэсэг гарч удирдамж, төлөвлөгөө
боловсруулан МХГазрын хөдөлмөрийн улсын
байцаагчийн хамтаар төрийн байгууллагуудад хуулийн
хэрэгжилтийг хангуулахаар хяналт шалгалт зохион
байгуулан ажилласан бөгөөд хяналт шалгалтын мөрөөр
гарсан танилцуулга болон албан шаардлагыг эргэж
хүргүүлсэн болно.

Хавсралт: 3 хуудастай

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭЧ Г.ХИШИГДАВАА



1200014

Тайлбар-1. Тайлангийн төслийн 1.1-д тайлбар, нотлох баримтуудыг ирүүлснийг
судлаж үзээд тайлбарыг хүлээн авч Төрийн аудитын тухай хуулийн 19.3.2-т заасны
дагуу тайлангийн төсөлд нэмэлт өөрчлөлт орууллаа.

Тайланг баталгаажуулсан тушаал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/30

Мандагзовь

Эрсдэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40 -д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний Аудитын газрын харьяа Дундговь аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудитын тайлан ДУАГ/2016/03-ЭА/-г баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хийсэн эрсдэлийн аудитын тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга /Г.Хишигдаваа /-д хүргүүлсүгэй.

4. Эрсдэлийн аудитаар илэрсэн зөрлүүдийг арилгаж, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2016 оны 12 дугаар сарын 15-ний дотор Аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга /Г.Хишигдаваа/-д зөвлөсүгэй.

5. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2016 оны 4 дугаар улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, Санхүүгийн аудитын багийн ахлах аудитор /Б.Гантуяа/ нарт үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ОЮУНЧИМЭГ



D:\office\tushaal\A4\Haan bank.docx

1906000071

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2015 он, 2016 оны 2 дугаар улирлын
санхүүгийн үйл ажиллагаа

Түрүүлэгч ажлын үйлдвэрлэл
2016 оны 1-р сарын 1-н
ХТЗО-н үйлдвэрлэл
2016 оны 1-р сарын 1-н

САНХҮҮГИЙН ТЭЙЛГЭЭНИЙ ӨНГӨНГӨН ӨНГӨНГӨН

№	Тайлбар	Ажлын үйлдвэрлэл	Өнгийн үйлдвэрлэл	Өнгийн үйлдвэрлэл	Өнгийн үйлдвэрлэл	Өнгийн үйлдвэрлэл	Өнгийн үйлдвэрлэл	Өнгийн үйлдвэрлэл	Өнгийн үйлдвэрлэл	Өнгийн үйлдвэрлэл
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	авалгын дүнг	2015 оны жилийн эцэст авалгын үйлдвэрлэл бэлтгэжүүлж тооцоо нийлүүлж			237,177.8			237,177.8		237,177.8
2	авалгын дүнг	2016 оны жилийн хугацаа хүснэгтээр эзэлжүүлж үйлдвэрлэл			50,001.5			50,001.5		50,001.5
3	орлогын дүнг	Хөгжлийн бэрхшээлтэй бусууд олон ажилуулалтай туслах. Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолын дагуу 25 ас дээр ажиглалтай ААН байгууллагаас авах боломжийг алдсан			31,104.0			31,104.0		31,104.0
4	зарлагын дүнг	Санхүүгийн дэмжлэг олгох, гурван бэлтгэжүүлж байхад дэмжлэгийн олгосон			1,800.0			1,800.0		1,800.0
5	зарлагын дүнг	Улаанбаатар хотын харьяатай 2 нэгж санхүүгийн дэмжлэг олгосон			1,400.0			1,400.0		1,400.0
6	зарлагын дүнг	шагхуун орлого авалгүй, шагхууны зарцуулалтыг бэлтгэсэн жилийн нормоор тооцоо болж бэлтгэжүүлж			10,196.3			10,196.3		10,196.3
7	орлогын дүнг	Арижааны банктай хамтран ажиллахар 2013 оны 09 дүгээр сард байгуулсан гэрээний дагуу олгосон эзэлжүүлж үйлдвэрлэл ХТЗО-н буцаан товруулжгүй			31,956.0			31,956.0		31,956.0
		Дүн			365,635.6			365,635.6		365,635.6